


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: 2.1%,
Инфляци: 2020 онд: 6.6%,
Урсгал тэнцэл: 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>


ДНБ-ий өсөлт: 2020 онд: -1%
Инфляци: 2020 онд: 5.6%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: -10.2%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 4-р сарын байдлаар (643.5) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 176.4 хувиар, зарлага 278.9 хувиар тус тус нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл (643.5) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 930 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 14.1 төгрөгөөр өсөв.

Дөрөвдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 148 төгрөг буюу 5.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 14.1 төгрөг буюу 0.5 хувиар, өмнөх улирлаас 1.4 хувиар өсч 2783.20 төгрөг болов. Гадаад валютын нөөц 3.8 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 6.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өссөн бол, оны эхнээс 12 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 4.7%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 4-р сарын байдлаар өмнөх сараас -0.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар, оны эхнээс 2.2 хувь өсөв. Үүнд хүнсний бараа, согтууруулах бус ундаа, хувцас, бөс бараа, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний өссөн нь голлон нөлөөлжээ.




Гадаад худалдааны тэнцэл 212.7 сая.ам долларын алдагдалтай гарав.

2020 оны дөрөвдүгээр сард нийт барааны эргэлт 2959 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 30.8 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 45.3, импорт өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 212.7 сая ам.долларын алдагдалтай гарав.



4-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ

Эх сурвалж: www.1212.mn

ДНБ 2020 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 7.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 18,763 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч эдийн засгийн өсөлт 10.7 хувиар буурав. 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ний 10.7 хувийн бууралтад уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 269.2 (29.5%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 114.9 (6.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв. ДНБ, 2020 оны эхний улиралд 10.7 хувиар буурсны (-7.6) пункт нь уул уурхай, олборлолтын салбарт, (-2.1) пункт нь тээвэр, мэдээлэл холбооны салбарт, (-1.3) пункт нь бөөний, жижиглэн худалдааны салбарт, (-1.0) пункт нь бүтээгдэхүүний цэвэр татварт тус тус ногдож байна.

САРЫН ОНЦЛОХ

БОДЛОГЫН ХҮҮ 9 ХУВЬ БОЛОВ.

- Монголбанкны Мөнгөний бодлогын хороо хуралдаж бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувь болгох, эргэн төлөлт нь хүндэрсэн зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргав. Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзэж эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор бодлогын хүүг бууруулахын зэрэгцээ хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар 1 удаа сунгаж, зээлийн сарын эргэн төлөлтийн хэмжээг бууруулах бодлогын багц шийдвэр гаргав.

АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН ЭХНИЙ САРУУДАД

- Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2020 оны 3 дугаар сарын эцэст 31.8 мянга болов. Өнгөрсөн сард 4.4 мянган хүн шинээр бүртгүүлсний 58.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна. Нийт ажил хайгчдын 19.4 (61.0%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 12.4 (39.0%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 3 дугаар сарын эцэст ажилгүй 4.4 мянган иргэн шинээр бүртгүүлсэн байна. 1.1 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 4.6 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Үүнээс Улаанбаатар хотод 2020 оны 3 дугаар сарын эцэст нийт 1.8 мянган иргэн нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 528 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 4-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 4-р сар 2020 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn